www.selenge.nso.mn



# Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2017 оны эхний 8 сард

www.1212.mn

ҮНДЭСНИЙ СТАТИСТИК

# БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

997 иргэн
сарын эхэнд

910 иргэн
сарын сүүлд

Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс идэвхгүйн улмаас 164 хүн хасагдаж, 33 хүн ажилд зуучлагдан орж, 110 хүн шинээр бүртгэгдсэн байна. Шинээр 380 ажлын байр бий болж боловсруулах үйлдвэр, худалдаа гэр ахуйн засвар үйлчилгээ, ХАА ан агнуур ой аж ахуй загас агнуур, уул уурхай олборлох үйлдвэрийн салбар тус тус 71.3 хувийг эзлэж байна.

## Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд

Өмнөх оны мөн үе
10.4%

Өмнөх сараас
8.7%

52.7%

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 95 (10.4%) хүнээр өсч, харин өмнөх сараас 87 (8.7%) хүнээр буурчээ, 910 болсны 480 (52.7%) нь эмэгтэйчүүд байна.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР



# БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 56.7 хувийг 25-34 насны залуучууд эзэлж, Бэлчирийн бүсэд 299, Ерөөгийн бүсэд 53, Хараагийн бүсэд 385, Орхоны бүсэд 105, Сэлэнгийн бүсэд 68 бүртгэлтэй ажилгүй иргэд байна.

Бэлчирийн бүс
32.8%

Ерөөгийн бүс
5.8%

Хараагийн бүс
32.8%

Орхоны бүс
11.5%




Сэлэнгийн бүс
7.4%

# НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 8 сард 18731.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1207.2 (6.4%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 8276.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1190.4 (14.3%) сая төгрөгөөр өссөн байна.

03

2017 оны 8 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 15750 тэтгэвэр авагчдад 36335.7 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 4445 хүнд 1477.1 сая төгрөгийг ХЧТА, ЖА, оршуулга, өвчтөн сахисны тэтгэмжид, ҮОМШӨ-ний даатгалын сангаас ҮО-ийн тэтгэвэр, ХЧТА-ны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 293 хүнд 728.3 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 391 хүнд 527.7 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, ЭМД-ын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 3008.3 сая төгрөгийн зардлыг тус тус олгожээ.

# ЭРҮҮЛ МЭНД



Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 8 сард 1128 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1133 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 118 (10.4 %)-иар, амьд төрсөн хүүхэд 122 (10.7%)-иар буурсан байна.



Аймгийн хэмжээгээр 0-1 хүртэлх хүүхдийн эндэгдэл 12, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2017 оны 8 сард 468 болж, өмнөх оны мөн үеэс 1108 (70.3%)-иар буурсан шалтгаан нь Улаан бурхан өвчлөл их гарсантай холбоотой байлаа.

# ГЭМТ ХЭРЭГ

## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2015 I-VIII → **534**

2016 I-VIII → **482**



2017 I-VIII → 493

2017 оны 8 сарын байдлаар бүртгэгдсэн захиргааны зөрчил 14941 бүртгэгдсэний 14912 иргэн, 29 ААН, байгууллагад торгуулийн арга хэмжээ авч, 587 хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулжээ.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр




БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 8 сар



# МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААС

Монгол банкны мэдээгээр энэ сард кассын цэвэр орлого 61919.4 сая төгрөг, цэвэр зарлага 59838.7 сая төгрөгт хүрчээ. Зээлийн өрийн үлдэгдэл 225835.7 сая төгрөг байгаа ба үүний 2.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 70667.0 сая төгрөг байна.

Арилжааны банкны харилцахын үлдэгдэл 2017 оны 8 дугаар сарын эцэст 25241.7 сая төгрөг болж, өмнөх сараас 6589.6 (20.7%) сая төгрөг, өмнөх оны мөн үеэс 30436 (54.6%) сая төгрөгөөр тус тус буурчээ.




Арилжааны банкны зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 8 дугаар сарын эцэст 225835.7 сая төгрөг болж, өмнөх сараас 5768.4 (2.5%) сая өсч, өмнөх оны мөн үеэс 26319.6 (11.6%) сая төгрөгөөр өсчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2017 оны 8 дугаар сарын эцэст 5873.2 сая төгрөг болж, өмнөх сараас 269.4 (4.5 %) сая төгрөг өссөн бол өмнөх оны мөн үеэс 904.7 ( 15.4%) сая төгрөгөөр буурсан байна.

Монгол Банк

ТӨРИЙН БАНК

КАПИТАЛ БАНК

# Арилжааны банкны ханшийн мэдээ, ХААН БАНК 2017.09.11




43.7 төгрөг өмнөх оны мөн үеэс 8 төгрөг буюу 18.3% өссөн байна.




2456 төгрөг өмнөх оны мөн үеэс 228 төгрөг буюу 9.2% өссөн байна.




378.4 төгрөг өмнөх оны мөн үеэс 45.1 төгрөг буюу 11.9% өссөн байна.

# ОРОН НУТГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ

2017 оны төсвийн гүйцэтгэлийн 8 дугаар сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 98,4 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 100.0 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 87.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, аймгийн Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлага



## ГАДААД ХУДАЛДАА, мянган ам доллар



## ХӨДӨӨ АЖ АХУЙ



2016 оны мөн үеэс малын үнэ 10.000-240.000 төгрөгөөр буурсан байна. Түүхий эдийн үнийн хувьд адууны шир 5.000, үхрийн шир 6.000 - 13.000 төгрөгөөр тус бүр өссөн байна.





2017 оны 8 сарын мэдээгээр аймгийн хэмжээнд 157.7 мян.га-д үр тариа, 2.57 мян.га-д төмс, 2.5 мян.га-д хүнсний ногоо тус тус тариалжээ. Үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 10.4 мян.га буюу 7.1 хувиар их, төмс 0.69 мян.га буюу 22.3 хувиар, хүнсний ногоо 0.02 мян.га буюу 2.1 хувиар тус бүр бага тариалсан байна.



# ХӨДӨӨ АЖ АХУЙ





2017 оны 8 дугаар сарын ургац хураалтын явцын мэдээгээр үр тариа 1.95 мян.тн, төмс 1.7 мян.тн, хүнсний ногоо 5.7 мян.тн хураан авчээ. Үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 0.41 мян.тн буюу 26.6 хувиар, хүнсний ногоо 1.8 мян.тн буюу 44.1 хувиар тус бүр их, харин төмс 1.8 мян.тн буюу 2 дахин бага ургац хураан авсан байна.

**Үр тариа тариалалт /мян.га/**



# АЖ ҮЙЛДВЭР



2017 оны эхний 8-р сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 204.5 тэр.бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 254.3 тэр.бум төгрөгийн борлуулалт хийгсэн нь урьд оны мөн үеийнхээс үйлдвэрлэлт 16.1 хувиар буюу 39402.3 сая.төгрөгөөр буурсан бол борлуулалт 1.7 хувиар буюу 4323.6 сая.төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 24.3 хувь нь хүнсий салбарт 56.4 хувь нь уул уурхайн салбарт, 16.7 хувь нь барилгын материалын салбарт, 2.6 хувийг бусад салбарт бүтээгджээ. Сумдын жижиг дунд үйлдвэрүүд аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.3 хувьтай тэнцэх 656.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 765.5 сая.төгрөгийн борлуулалт хийжээ.

**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэр.бум төг)**



# ХИЛИЙН БООМТООР НЭВТЭРСЭН ЗОРЧИГЧ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ /2017.06.30/



Монгол → 387686

Гадаад → 79107



Суудлын → 98688

Ачааны → 34339



Суудлын → 2501

Ачааны → 91349

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистикийн лавлах
**1900-1212**

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
**www.1212.mn**

Статистик мэдээлэл

*www.nso.mn* сайтын
**Хэрэглэгчийн бүртгэлд**
бүртгүүлж мэдээлэл авах

@statistic_mn

www.selenge.nso.mn
www.facebook.com/selenge.statistic



**Утас: 7036-2449**
**7036-2047**